

## ЗЭСИЙН БАЯЖМАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

| ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ                         |   |
|---|---|
| 1. Төслийн нэр, хүчин чадал:                    | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр.<br>Жилд 257 мянган тонн катодын зэс, 5880тн алт үйлдвэрлэнэ.   |
| 2. Төсөл хэрэгжих салбар, дэд салбар:           | Хүнд үйлдвэрийн салбар. Өнгөт төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл  |
| 3. Төслийн хэрэгжих хугацаа:                    | 2017-2020 он  |
| 4. Төслийн хөрөнгө оруулалт /тэрбум ам.доллар/: | 2.3   |
| 5. Хэрэгжүүлэгч яам, байгууллага:               | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам   |
| ТӨСЛИЙН ТАЛААРХ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ           |   |
| 6. Бүтээгдэхүүн:                                | Төслийн хүрээнд жилд 1 сая тн. зэсийн баяжмалыг боловсруулж 257 мян.тн катодын зэс үйлдвэрлэнэ.   |
| 7. Төслийн үндэслэл:                            | <p>-Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>-Улсын Их Хурлын “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 10.4 дэх заалтад Зэс хайлуулах үйлдвэрийг барьж байгуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр тусгасан.</p> <p>-Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.</p> <p>-Эдийн засгийг сэргээх хөтөлбөр.</p> <p>-Монгол Улсын Засгийн газрын “Төслийн нэгж байгуулах тухай” 2016 оны 09 дүгээр сарын 28 –ны өдрийн 107 дугаар тогтоол.</p> <p>-Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” 88 дугаар тогтоол.</p> |
| 8. Төслийн зорилго:                             | Монгол Улсын зэсийн нөөцөд тулгуурлан цэвэр зэс үйлдвэрлэх, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс суурийг тавихад төслийн үндсэн зорилго оршино.  |
| 9. Хүрэх үр дүн:                                | -Монгол улс дотооддоо үйлдвэрлэсэн зэс, түүгээр хийсэн бүтээгдэхүүнээр өөрийгөө бүрэн хангаж, эцсийн бүтээгдэхүүн экспортлогч орон болно.   |

-Тухайн үйлдвэрийг дагалдан туслах үйлдвэрүүд, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч жижиг, дунд үйлдвэрлэл хөгжинө.

-Үйлдвэрлэлд байгаль орчин, нийгэмд аюулгүй техник, технологи нэвтэрнэ.

-Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс техник технологи, ажлын байр, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартуудыг эзэмшсэн, дотоод, гадаадын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц дадлага туршлагатай ажиллах хүчин бий болно.

-Их дээд сургууль болон техник мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөр шинэчлэгдэж, шинэ төрлийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоо бүрдэнэ.

-Экспортын болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг шинээр бий болгосноор манай улсын гадаад худалдааны тэнцэлд эерэг нөлөө үзүүлнэ.

-Орон нутагт 580 шууд ажлын байр шинээр бий болгоно.